

**ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН  
ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ  
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН  
ЗАСАГ ЗАХИРГААНЫ ОНЦГОЙ БҮС МАКАО,  
МОНГОЛ УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төв Засгийн газраас энэхүү хэлэлцээрийг байгуулах бүрэн эрх авсан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макао (“Засаг захиргааны онцгой бүс Макао”) болон Монгол Улс (цаашид “талууд” гэх),

Хоёр талын эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хамтын ажиллагааг боловсронгуй болгохыг эрмэлзэн,

Дараахь зүйлсийг хэлэлцэн тохиролцов. Үүнд:

**1 ДҮГЭЭР ЗҮЙЛ**  
**Хэлэлцээрийн үйлчлэх хүрээ**

1. Талууд энэхүү хэлэлцээрт заасны дагуу эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлнэ.

2. Энэхүү хэлэлцээрт заасны дагуу дараахь эрх зүйн туслалцааг үзүүлнэ. Үүнд:

(a) холбогдох этгээдийн байршлыг тогтоох болон танин тогтоох;

(b) баримт бичиг гардуулах;

(c) нотлох баримт, эд зүйлс, эсхүл баримт бичиг олж авах;

(d) нэгжлэг хийх болон эд зүйл хураан авах;

(e) саатуулагдсан болон бусад этгээдийг түр шилжүүлэх;

(f) гэмт хэргийн улмаас олдсон хэрэгсэл болон орлогыг илрүүлэх, зогсоох, хураах;

(g) шүүхийн, эсхүл албаны мэдээлэл, баримт бичиг болон хэргийн материалаар хангах;

(h) эд хөрөнгө илгээх болон эд зүйлсийг түр хугацаагаар өгөх;

(i) хүсэлт хүлээн авагч талын хуульд харшлаагүй бусад хэлбэрийн туслалцаа.

3. Энэхүү хэлэлцээрийн зорилгоор “эрүүгийн хэрэг” гэдэгт туслалцаа үзүүлэхийг хүссэн хүсэлт гаргах үед хүсэлт гаргагч талын шүүхийн харьяаллын хүрээнд байгаа хэрэгт мөрдөн байцаах, яллах, эсхүл хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахыг ойлгоно.

4. Энэхүү хэлэлцээр нь дараахь зүйлд хамаарахгүй. Үүнд:

(a) оргон зайлсан гэмт этгээдийг шилжүүлэх;

(b) хүсэлт хүлээн авагч талын хууль тогтоомж болон энэхүү хэлэлцээрийн 16, 17 дугаар зүйлд зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд хүсэлт гаргагч талын гаргасан эрүүгийн хэрэгт холбогдох шүүхийн шийдвэрийг хүсэлт хүлээн авагч талд биелүүлэх;

(c) ял эдлүүлэх зорилгоор ялтан шилжүүлэх;

(d) эрүүгийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг шилжүүлэх.

5. Энэхүү хэлэлцээр нь талуудын хооронд гагцхүү эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхэд чиглэгдсэн байна. Энэхүү хэлэлцээрийн заалт нь аливаа этгээдэд нотлох баримтыг олж авах, нуун дарагдуулах болон хасах, эсхүл хүсэлтийг гүйцэтгэхэд саад учруулах ямар нэг эрх үүсгэхгүй.

6. Энэхүү хэлэлцээрийн аль ч заалт нь нөгөө талын шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, эсхүл нөгөө талын эрх бүхий байгууллагын хуулиар хамгаалагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөл болохгүй.

## **2 ДУГААР ЗҮЙЛ**

### **Эрх бүхий төв байгууллага**

1. Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор талууд өөрсдийн эрх бүхий төв байгууллагаар дамжуулан харилцана.

2. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макаогийн эрх бүхий төв байгууллага нь Ерөнхий прокурорын газар байна. Монгол Улсын эрх бүхий төв байгууллага нь Хууль зүй, дотоод хэргийн яам байна.

3. Аль ч тал өөрсдийн эрх бүхий төв байгууллагаа өөрчилж болох бөгөөд энэхүү өөрчлөлтийн талаар нөгөө талдаа даруй бичгээр мэдэгдэнэ.

4. Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор эрх бүхий төв байгууллага хоорондоо шууд, эсхүл дипломат шугамаар харилцана.

## **3 ДУГААР ЗҮЙЛ**

### **Туслалцаа үзүүлэхээс татгалзах үндэслэл**

Хүсэлт хүлээн авагч тал өөрийн хуулийн хүрээнд дараахь тохиолдолд туслалцаа үзүүлэхээс татгалзана. Үүнд:

(а) Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макаогийн хувьд хүсэлтийг биелүүлэх нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын үндэсний батлан хамгаалах, гадаад бодлого, тусгаар тогтнол, эсхүл Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нутаг дэвсгэрийн аль ч хэсгийн болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макаогийн нийгмийн хэв журам, эсхүл нийтийн үндсэн эрх ашигт хохирол учруулахаар бол, эсхүл Монгол Улсын хувьд хүсэлтийг биелүүлэх нь тусгаар тогтнол, аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эсхүл нийтийн үндсэн эрх ашигт хохирол учруулахаар бол;

(b) хүсэлт хүлээн авагч тал тухайн туслалцаа үзүүлэх гэмт хэргийг улс төрийн болон улс төрийн шинжтэй гэмт хэрэг гэж үзэх хангалттай үндэслэл байгаа бол. Улс төрийн гэмт хэрэгт дараахь хэрэг хамаарахгүй. Үүнд:

- (i) Төрийн тэргүүн болон Засгийн газрын тэргүүн, түүний гэр бүлийн гишүүдийн амь насыг хохироосон болон хохироохоор завдсан, эсхүл халдан довтолсон болон довтолохоор завдсан;
- (ii) Талуудын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээнээс үүдэлтэй улс төрийн гэмт хэрэг болон улс төрийн шинжтэй гэмт хэрэгтэй холбоотой ямар ч гэмт хэрэг;

(c) хүсэлт хүлээн авагч талын хуулиар тухайн хүсэлт нь эрүүгийн гэмт хэрэгт хамааралгүй, цэргийн хуулиар зохицуулагдах гэмт хэрэг бол;

(d) хүсэлт нь тухайн этгээдийг үндэс угсаа, арьс өнгө, хүйс, шашин шүтлэг, иргэний харьяалал, хэл, улс төр болон ертөнцийг үзэх үзэл бодол, боловсролын түвшин, эдийн засгийн байдал болон нийгмийн түвшин, эсхүл аль нэг нийгмийн бүлэгт хамаарагддаг эсэхээс нь шалтгаалж хянан шийдвэрлэх болон шийтгэх зорилготой, эсхүл тухайн этгээдийн эрх ашгийг дээрх аль нэг шалтгаанаар хохирооно гэж үзэх хангалттай үндэслэлтэй бол;

(e) хүсэлт гаргагч талаас мөрдөн байцаах, яллах, эсхүл хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах гэмт хэрэгт хүсэлт хүлээн авагч талын хуулиар яллах ажиллагаа дууссан, хэргийг хэрэгсэхгүй болгосон, эсхүл өршөөл үзүүлсэн бол;

(f) хүсэлт хүлээн авагч талын нутаг дэвсгэрт үйлдсэн үйлдэл нь гэмт хэрэгт тооцогдохгүй бол;

(g) хүсэлт хүлээн авагч талын нутаг дэвсгэрт үйлдсэн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэмт хэрэгт холбогдох этгээдийг яллахтай холбоотой гаргасан хүсэлт;

(h) хүсэлт нь хүсэлт гаргагч талын хуулиар цаазаар авах, бүх насаар нь хорих, тодорхой бус хугацаагаар хорих болон тухайн этгээдийн эрх ашиг нэр хүндийг дахин засан сэргээх боломжгүйгээр хохироон сүйтгэх аль нэг шалтгаанаар хохироохгүй байх хангалттай нотолгоог гаргаж өгөөгүй тохиолдолд хүсэлт хүлээн авагч тал туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно.

#### **4 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

##### **Хүсэлтийн агуулга**

1. Эрх зүйн туслалцаа хүссэн хүсэлтийг бичгээр гаргана. Яаралтай тохиолдолд, хүсэлт хүлээн авагч талд хүсэлтийг өөр хэлбэрээр гаргаж болох бөгөөд түүнээс хойш арван тав (15) хоногийн дотор баталгаажуулан бичгээр хүргүүлнэ.

2. Хүсэлтэд дараахь зүйлсийг агуулна. Үүнд:

(a) талуудын хүсэлтэд дурдсан хамаарал бүхий эрх бүхий байгууллагын нэр;

(b) хүсэлтийн зорилго болон туслалцааны тайлбар;

(c) мөрдөн байцаах, эсхүл хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго, хэлбэр болон холбогдох хууль тогтоомжийн талаарх танилцуулга;

(d) нууцлалын шаардлага болон түүний шалтгаан;

(e) хүсэлт хүлээн авагч талаас хүсэлтэд дурдсан асуудлаар аливаа арга хэмжээ авахыг хүссэн хүсэлт;

(f) хүсэлтийг гүйцэтгэвэл зохих хугацаа.

3. Туслалцаа хүссэн хүсэлтэд шаардлага, бололцооны хүрээнд дараахь зүйлсийг тусгана. Үүнд:

(a) нотлох баримт авах шаардлагатай этгээдийн хувийн мэдээлэл, харьяалал, оршин байгаа газрын мэдээлэл;

(b) тухайн этгээдийн ямар хэргээр шалгагдаж байгаа болон тухайн этгээдээс тодруулах асуултын жагсаалт;

(c) баримт бичиг гардуулах этгээдийн хувийн болон оршин байгаа газрын мэдээлэл, мөрдөн байцаалт болон хянан шийдвэрлэх ажиллагаатай харилцан хамаарал болон гардуулж өгөх арга замын талаарх мэдээлэл;

(d) хүсэлт гаргагч талд биеэр байлцах этгээдийн зардал болон авбал зохих амьжиргааны тэтгэмж болон зардлын талаарх мэдээлэл;

(e) тухайн этгээдийн хувийн болон оршин байх газрын мэдээлэл;

(f) эрэн сурвалжлагдаж байгаа этгээдийн болон хураан авсан болон ирүүлэхийг хүссэн эд хөрөнгийн талаарх мэдээлэл;

(g) хүсэлтийг зохих ёсоор гүйцэтгэхэд шаардагдах бусад мэдээлэл;

4. Хэрэв хүсэлт хүлээн авагч тал хүсэлтэд дурдсан мэдээлэл хүсэлтийг биелүүлэхэд хангалтгүй гэж үзвэл нэмэлт мэдээллийг хүсэлт гаргагч талаас хүсэж болно.

5. Энэхүү хэлэлцээрийн дагуу баримт бичгийг хүсэлт хүлээн авагч талын албан ёсны хэл, эсхүл англи хэлээр орчуулж хавсаргана.

## **5 ДУГААР ЗҮЙЛ**

### **Хүсэлтийг гүйцэтгэх**

1. Хүсэлт хүлээн авагч тал өөрийн хуулийн хүрээнд хүсэлтийг даруй гүйцэтгэнэ. Хэрэв хүсэлт хүлээн авагч талын хуулиар хориглоогүй бол хүсэлт гаргагч талын тодорхойлсон хэлбэрээр гүйцэтгэж болно.

2. Хүсэлт хүлээн авагч талын мөрдөн байцаах болон хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлж болзошгүй тохиолдолд хүсэлт хүлээн авагч тал эрх зүйн туслалцаа үзүүлэхээ хойшлуулж болно.

3. Хүсэлт хүлээн авагч талд хүсэлтийг гүйцэтгэхэд мэдэгдэхүйц саатал учрах нөхцөл байдал илэрсэн тохиолдолд тухайн нөхцөл байдлын талаар хүсэлт гаргагч талд даруй мэдэгдэнэ.

4. Хүсэлт хүлээн авагч тал хүсэлтийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг гүйцэтгэхгүй байх тухай шийдвэр, шалтгааныг хүсэлт гаргагч талд нэн даруй мэдэгдэнэ.

5. Хүсэлт хүлээн авагч тал эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзах, эсхүл хойшлуулах тохиолдолд дараахь арга хэмжээг авна. Үүнд:

(а) Хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзах, эсхүл хойшлуулах болсон шалтгааныг нэн даруй хүсэлт гаргагч талд мэдэгдэнэ.

(b) Хүсэлт хүлээн авагч талаас шаардлагатай гэж үзсэн нөхцөл байдлын дагуу эрх зүйн туслалцаа үзүүлж болох эсэхийг хүсэлт хүлээн авагч талтай тодорхойлон зөвлөлдөнө.

6. Хэрэв хүсэлт гаргагч тал тус зүйлийн 5 (b) дэд хэсэгт заасан туслалцааны нөхцөлийг хүлээн авбал тухайн нөхцөлийг дагах үүрэгтэй.

7. Хүсэлт гаргагч талын хүсэлтийн дагуу, хүсэлт хүлээн авагч тал эрх зүйн туслалцааг гүйцэтгэх огноо болон байршлыг хүсэлт гаргагч талд мэдэгдэж, хүсэлт хүлээн авагч тал хэрэв зөвшөөрсөн тохиолдолд хүсэлт гаргагч талын холбогдох эрх бүхий этгээдийг оролцуулах болно.

8. Хүсэлт хүлээн авагч тал эрх зүйн туслалцааг гүйцэтгэсэнтэй холбогдох үр дүнг хүсэлт гаргагч талд даруй мэдэгдэнэ.

## **6 ДУГААР ЗҮЙЛ**

### **Ашиглалтын хязгаарлал**

Хүсэлт гаргагч тал энэхүү хэлэлцээрийн хүрээнд авсан аливаа мэдээлэл болон нотлох баримтыг мөрдөн байцаалт, яллах болон хянан шийдвэрлэх ажиллагаанаас бусад тохиолдолд хүсэлт хүлээн авагч талын урьдчилсан зөвшөөрөлгүйгээр ашиглах, эсхүл шилжүүлж болохгүй.

## **7 ДУГААР ЗҮЙЛ**

### **Нууц хадгалалт**

1. Хүсэлт хүлээн авагч тал нь эрх зүйн туслалцаа үзүүлэхийг хүссэн хүсэлт, түүний агуулга, холбогдох бусад баримт бичиг болон хүсэлтийн дагуу авсан арга хэмжээний талаарх нууцлалыг чандлан хадгалахад дээд зэргийн хүчин чармайлт гаргана. Хэрэв хүсэлт биелүүлэх явцад нууцыг задруулалгүйгээр хүсэлтийг гүйцэтгэх боломжгүй гэж үзвэл хүсэлт хүлээн авагч тал энэ тухай хүсэлт гаргагч талд мэдэгдэж, тухайн хүсэлтийг үргэлжлүүлэн биелүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

2. Хүсэлт гаргагч тал хүсэлт хүлээн авагч талын зүгээс нууцлахыг хүссэн мэдээлэл, нотлох баримтыг мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаанаас бусад тохиолдолд нууцална.

## **8 ДУГААР ЗҮЙЛ**

### **Холбогдох этгээдийн байршлыг тогтоох болон таньж олуулах**

Хүсэлтэд аль нэг хүний байршлыг тогтоох болон таньж олуулахаар хүссэн бол хүсэлт хүлээн авагч тал хүсэлтийг биелүүлэхийг эрмэлзэнэ.

## **9 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

### **Нотлох баримт, эд зүйл, баримт бичиг олж авах**

1. Хүсэлт хүлээн авагч тал өөрийн хуулийн хүрээнд нотлох баримт, мэдүүлэг авах, эсхүл хүсэлт гаргагч талд шилжүүлэн өгөх зорилгоор нотлох баримт, холбогдох мэдээлэл бусад материалыг гаргуулан авна.



2. Хүсэлт хүлээн авагч тал өөрийн хуулийн хүрээнд хүсэлтийг гүйцэтгэх явцад хүсэлтэд дурдсан төлөөлөгчийг оролцуулахыг зөвшөөрөх бөгөөд уг этгээдэд мэдүүлэг, эсхүл нотлох баримт авах этгээдээс байцаалт авахыг зөвшөөрч болно. Хэрэв шууд байцаалт авахыг зөвшөөрөхгүй тохиолдолд уг этгээдээс мэдүүлэг, эсхүл нотлох баримт авах этгээдээр дамжуулж асуулт асуухыг зөвшөөрч болно.

3. Хүсэлт хүлээн авагч талд нотлох баримт гаргаж өгөх тухайн этгээд дараахь тохиолдолд нотлох баримт гаргаж өгөхөөс татгалзаж болно:

(a) хүсэлт хүлээн авагч талын хуулиар хүсэлт хүлээн авагч талаас үүсгэсэн хэрэгтэй ижил төстэй нөхцөлд нотлох баримт өгөхөөс татгалзаж болохыг тухайн этгээдэд зөвшөөрсөнд; эсхүл

(b) Хүсэлт гаргагч талын хуулиар хүсэлт гаргагч талын тухайн хэрэгт нотлох баримт өгөхөөс татгалзахыг түүнд зөвшөөрсөн бол.

4. Хэрэв хүсэлт гаргагч талын хуулийн дагуу тухайн этгээд нотлох баримт гаргаж өгөхөөс татгалзах эрхтэй гэж үзвэл хүсэлт хүлээн авагч тал заавал хүсэлт гаргагч талын эрх бүхий байгууллагаас баталгааг гаргуулна.

## **10 ДУГААР ЗҮЙЛ**

### **Баримт бичиг гардуулах**

1. Хүсэлт хүлээн авагч тал өөрийн хуулийн хүрээнд, хүсэлт гаргагч талаас түүнд шилжүүлсэн баримт бичгийг аль болох боломжийн хэмжээнд гардуулна.

2. Аль нэг этгээдийг хүрэлцэн ирэхийг шаардсан баримт бичгийг гардуулах хүсэлтийг тухайн этгээд хүрэлцэн ирсэн байх өдрөөс ер (90) хоногийн өмнө хүсэлт хүлээн авагч талд хүргүүлнэ. Яаралтай тохиолдолд, хүсэлт хүлээн авагч тал энэхүү шаардлагаас татгалзаж болно.

3. Хүсэлт хүлээн авагч тал нь дээрх баримт бичгийг гардуулсан нотолгоог огноо, газар, байршлын мэдээллийг тайлбарын хамт эрх бүхий байгууллагын тамга, эсхүл тэмдэг дарж, гарын үсэг зурж хүсэлт гаргагч талд илгээнэ. Хэрэв ийнхүү гардуулах ажиллагааг хүчин төгөлдөр хэрэгжүүлж чадаагүй бол шалтгааныг мэдэгдэнэ.

4. Баримт бичигт заасан аливаа шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тухайн этгээдэд аль нэг талын хуулийн дагуу ямар нэг торгууль, эсхүл албадлагын арга хэмжээ, хариуцлага хүлээлгэхгүй.

#### **11 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

##### **Хүсэлт хүлээн авагч талд эд зүйл буцаах**

Хүсэлт гаргагч тал энэхүү хэлэлцээрийн дагуу олж авсан материалыг хүсэлт хүлээн авагч талд шаардлагатай тохиолдолд нэн даруй буцаана.

#### **12 ДУГААР ЗҮЙЛ**

##### **Нийтэд нээлттэй байх албан ёсны баримт бичиг**

1. Хүсэлт хүлээн авагч тал өөрийн хуулийн хүрээнд нийтэд нээлттэй албан ёсны баримт бичгийн хуулбарыг өгнө.

2. Хүсэлт хүлээн авагч тал Засгийн газрын байгууллага болон агентлагийн эзэмшилд байгаа ил болоогүй, өөрийн хууль хяналтын болон шүүх байгууллагад байгаа баримт бичгийг адил нөхцөлийн дагуу гаргаж өгч болно.

#### **13 ДУГААР ЗҮЙЛ**

##### **Нотлох баримт гаргаж өгөх, мөрдөн байцаалтад оролцуулах зорилгоор хоригдож буй этгээдийг шилжүүлэх**

1. Хүсэлт хүлээн авагч тал хоригдож буй этгээдийг хүсэлт гаргагч талын хүсэлт мөн тухайн этгээд болон хүсэлт хүлээн авагч талын бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр нотлох баримт гаргуулах болон мөрдөн байцаах ажиллагаанд оролцуулах зорилгоор хүсэлт гаргагч талд түр хугацаагаар шилжүүлэн өгч болох бөгөөд, хүсэлт гаргагч тал хоригдож буй этгээдийг үргэлжлүүлэн хорьж түүнийг буцааж хүргүүлэх баталгааг гаргаж өгнө.

2. Хүсэлт хүлээн авагч тал хоригдож буй этгээдэд оролцохоос татгалзах болон тус хэлэлцээрийн 15 дугаар зүйлд заасан халдашгүй эрхийн талаар мэдэгдэнэ.

3. Шилжүүлэгдсэн этгээдийн хорих ялын хугацаа хүсэлт гаргагч талд байхад дуусгавар болсон тохиолдолд хүсэлт хүлээн авагч тал түүнийг хорих ялаас чөлөөлөхийг хүсэлт гаргагч талд зөвлөнө.

4. Энэхүү зүйлд заасны дагуу шилжүүлэгдсэн этгээдийн хүсэлт гаргагч талд хоригдож байсан хугацааг хүсэлт хүлээн авагч талын ял эдэлсэн хугацаанд оруулж тооцно.

## **14 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

### **Туслалцаа үзүүлэх зорилгоор бусад этгээдийг шилжүүлэх**

1. Хүсэлт гаргагч тал энэхүү хэлэлцээрийн дагуу мөрдөн байцаах ажиллагаанд туслалцаа үзүүлэх, эсхүл нотлох баримт гаргуулах зорилгоор аливаа этгээдийг ирүүлэх талаар туслалцаа үзүүлэхийг хүсэлт хүлээн авагч талд гаргаж болно. Хүсэлт гаргагч тал тухайн этгээдэд олгогдох зардал болон тэтгэмжийн хэмжээг тодорхойлон зааж өгнө.

2. Хүсэлт хүлээн авагч тал тухайн этгээдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хүсэлт гаргагч талаас хангасан гэж үзвэл нотлох баримт гаргаж өгөх, мөрдөн байцаах ажиллагаанд туслалцаа үзүүлэх этгээдийг хүсэлт гаргагч талд зорчихыг мэдэгдэнэ.

3. Хүсэлт хүлээн авагч тал ирүүлэх гэж буй этгээдэд татгалзах болон тус хэлэлцээрийн 15 дугаар зүйлд заасан халдашгүй эрхийн талаар мэдэгдэнэ.

4. Хүсэлт хүлээн авагч тал хүсэлт гаргагч талд тухайн этгээдийн хариуг даруй мэдэгдэнэ. Хэрэв тухайн этгээд зөвшөөрсөн тохиолдолд, хүсэлт хүлээн авагч тал түүнийг хүсэлт гаргагч талд байлцуулах талаар шаардлагатай арга хэмжээг авна.

## **15 ДУГААР ЗҮЙЛ**

### **Баталгаа гаргах**

1. Тус хэлэлцээрийн 13 болон 14 дүгээр зүйлд заасны дагуу нотлох баримт гаргаж өгөх, эсхүл мөрдөн байцаах ажиллагаанд туслалцаа үзүүлэхийг зөвшөөрсөн аливаа этгээдийг хүсэлт хүлээн авагч талаас явахаасаа өмнө холбогдсон аливаа үйлдэл, эс үйлдэл, эсхүл ял шийтгэлийн төлөө яллах, саатуулах, эсхүл хувийн эрх чөлөөг нь бусад хэлбэрээр хязгаарлан хориглохгүй, эсхүл тухайн этгээд хүсэлт хүлээн авагч талын хүсэлтэд дурдсанаас өөр мөрдөн байцаалт, эсхүл шүүн таслах ажиллагаанд нотлох баримт гаргаж өгөх, туслалцаа үзүүлэх үүрэг хүлээхгүй.

2. Тухайн этгээдийг биечлэн байлцах шаардлагагүй хэмээн албан ёсоор мэдэгдсэнээс хойш тухайн этгээд нь дөчин тав (45) хоногийн хугацаанд хүсэлт гаргагч талаас гарч явах нь чөлөөтэй боловч гарч яваагүй, эсхүл гарч явсан ч сайн дураар буцан ирсэн тохиолдолд энэхүү зүйлийн 1 дэх хэсэг үйлчлэхгүй.

3. Энэхүү хэлэлцээрийн 13 болон 14 дүгээр зүйлд заасны дагуу аливаа этгээд нотлох баримт гаргах, эсхүл мөрдөн байцаах ажиллагаанд туслалцаа үзүүлэхийг зөвшөөрөөгүй тохиолдолд аль нэг талын хуулийн дагуу ямар ч торгууль, эсхүл албадлагын арга хэмжээ, хариуцлага хүлээлгэхгүй.

## **16 ДУГААР ЗҮЙЛ**

### **Нэгжлэг хийх, эд зүйл хураан авах**

1. Хүсэлт хүлээн авагч тал өөрийн хуулийн хүрээнд нэгжлэг хийх, хураан авах болон шилжүүлэх үйл ажиллагаа явуулах, нэгжлэг хийсэн үр дүн, эд зүйл хураан авсан байршил, хэрхэн хураан авсан нөхцөл байдлын тухай болон хураан авсан эд зүйлийг битүүмжилсэн талаарх мэдээллээр хангана.

2. Хүсэлт хүлээн авагч тал өөрийн нөхцөлийн дагуу хүсэлт хүлээн авагч тал зөвшөөрсний үндсэн дээр хураагдсан эд зүйлсийг хүсэлт гаргагч талд шилжүүлж болно.

3. Тус зүйлийг хэрэгжүүлэхэд хүсэлт хүлээн авагч талын эрх, ашиг сонирхол болон гуравдагч этгээдийн шударгаар үйл ажиллагаа явуулах эрхийг зөрчихгүй байх ёстой.

## **17 ДУГААР ЗҮЙЛ**

### **Гэмт хэргийн улмаас олсон орлого**

1. Хүсэлт хүлээн авагч тал өөрийн шүүхийн харьяалалд гэмт хэргийн улмаас олдсон эд зүйл байгаа эсэхийг олж тогтоох талаар хүчин чармайлт гаргах бөгөөд түүний үр дүнг хүсэлт гаргагч талд мэдэгдэнэ. Хүсэлт гаргагч тал хүсэлт гаргахдаа хүсэлт хүлээн авагч талын шүүхийн харьяалалд тухайн орлого байж болох үндэслэлээ мэдэгдэнэ.

2. Дээрх 1 дэх хэсэгт заасны дагуу гэмт хэргийн улмаас олдсон орлого байгаа нь тогтоогдвол, тэдгээр орлогын талаар хүсэлт гаргагч талын шүүхийн эцсийн шийдвэр гартал хүсэлт хүлээн авагч тал хүсэлт болон өөрийн хуулийн хүрээнд тухайн орлогыг шилжүүлэх болон борлуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.

3. Гэмт хэргийн улмаас олсон орлогыг хураан авах тухай хүсэлтийг хүсэлт хүлээн авагч талын хуулийн хүрээнд зүй зохистой явуулна. Энэ нь хүсэлт хүлээн авагч талын шүүхээр баталгаажсан хүсэлт гаргагч талын шүүхээс гаргасан эцсийн шийдвэрийг агуулсан байна.

4. Хүсэлт хүлээн авагч тал хяналтдаа байлгаж буй хураагдсан орлогыг өөрийн хуулийн хүрээнд шийдвэрлэнэ. Хүсэлт хүлээн авагч тал өөрийн хууль тогтоомжийн дагуу болон зүй зохистой хэмээн үзсэн нөхцөлийн үндсэн дээр хураагдсан орлогыг хүсэлт гаргагч талд шилжүүлэн өгч болно.

5. Тус зүйлийг хэрэгжүүлэхэд талуудын эрх, ашиг сонирхол болон гуравдагч этгээдийн шударгаар үйл ажиллагаа явуулах эрхийг зөрчихгүй байх ёстой.

## **18 ДУГААР ЗҮЙЛ**

### **Гэрчлэх болон баталгаажуулах**

1. Дор дурдсан 2 дахь хэсгийн заалтын дагуу туслалцаа үзүүлэхийг хүссэн хүсэлт, түүний дагалдах баримт бичиг болон энэхүү хүсэлтийн дагуу өгсөн бусад баримт бичгийг гэрчлэх, эсхүл баталгаажуулахыг шаардахгүй.

2. Хүсэлт хүлээн авагч талын хууль тогтоомжид хориглоогүй бол аливаа баримт бичиг, тэмдэглэл болон бусад холбогдох материалыг хүсэлт гаргагч талын хууль тогтоомжид нийцүүлэх үүднээс хүсэлт гаргагч талын дурдсан хэлбэрээр, эсхүл гэрчилсэн баримтыг хавсаргаж шилжүүлнэ.

## **19 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

### **Төлөөлөл болон зардал**

1. Хүсэлт хүлээн авагч тал нь хүсэлтээс үүдэн гарах байцаан шийтгэх ажиллагаанд хүсэлт гаргагч талыг төлөөлөх бүх шаардлагатай арга хэмжээг авах бөгөөд бусад бүх асуудлаар хүсэлт гаргагч талын ашиг сонирхлыг төлөөлнө.

2. Хүсэлт хүлээн авагч тал өөрийн шүүхийн харьяалалд туслалцаа үзүүлэхийг хүссэн хүсэлтийг гүйцэтгэхтэй холбогдон гарах үндсэн зардлыг хариуцах бөгөөд хүсэлт гаргагч тал нь дор дурдсан зардлыг хариуцна. Үүнд:

(a) Хүсэлт гаргагч талын хүсэлтээр хүсэлт хүлээн авагч талын нутаг дэвсгэрээс тухайн этгээдийг шилжүүлэх, буцаах болон тус хэлэлцээрийн 13, 14 дүгээр зүйлийн дагуу хүсэлт гаргагч талд биечлэн байлцах хугацаанд тухайн этгээдэд өгөх тэтгэмж;

(b) шинжээчдийн төлбөр, зардал;

(c) хүсэлт гаргагч талын хүсэлтээр оролцуулсан зөвлөхийн төлбөр болон зардал;

(d) орчуулгын төлбөр;

(е) аливаа эд хөрөнгийг шилжүүлэхтэй холбоотой зардал.

3. Хэрэв хүсэлтийг биелүүлэхэд үлэмж их хэмжээний зардал шаардагдахаар бол талууд тухайн хүсэлтийг ямар болзол, нөхцөлийн дагуу хэрэгжүүлэх, эсхүл туслалцаа үзүүлэхийг зогсоох эсэх асуудлаар зөвлөлдөнө.

## **20 ДУГААР ЗҮЙЛ**

### **Зөвлөлдөх болон маргаан шийдвэрлэх**

Талуудын аль нэг эрх бүхий төв байгууллагын хүсэлтээр хэлэлцээрийг тайлбарлах, хэрэглэх, эсхүл хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар даруй зөвлөлдөнө. Талуудын эрх бүхий төв байгууллага тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд маргааныг дипломат шугамаар шийдвэрлэнэ.

## **21 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

### **Хүчин төгөлдөр болох, нэмэлт, өөрчлөлт оруулах болон цуцлах**

1. Тал тус бүр энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болоход шаардагдах дотоодын шаардлагыг биелүүлж дууссан тухай нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ. Энэхүү хэлэлцээр нь хоёр мэдэгдлийн хамгийн сүүлийн өдрөөс хойш гуч (30) хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү хэлэлцээрт талууд харилцан бичгээр тохиролцон нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Тус нэмэлт өөрчлөлт нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болно.

3. Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсноор аль нэг хүсэлтийн холбогдох үйлдэл, эс үйлдэл нь энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болоогүй байхад үүсэн гарсан зэргээс үл хамааран, бүхий л хүсэлтэд үйлчилнэ.

4. Аль ч тал нөгөө талдаа энэхүү хэлэлцээрийг цуцлах тухай мэдэгдлийг хэдийд ч бичгээр мэдэгдэж болно. Энэ тохиолдолд тус хэлэлцээр мэдэгдэл өгсөн өдрөөс хойш нэг зуун наян (180) хоногийн дараа хүчингүй болно.

5. Энэхүү хэлэлцээрийг дуусгавар болохоос өмнө хүлээн авсан эрх зүйн туслалцаа хүссэн хүсэлтийг эцэслэн шийдвэрлэтэл тус хэлэлцээрт заасны дагуу үйл ажиллагаа явуулна.

ДЭЭР ДУРДСАНЫГ НОТОЛЖ, талуудын Засгийн газраас бүрэн эрх олгосны дагуу энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурав.

Энэхүү хэлэлцээрийг 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдөр Улаанбаатар хотноо хятад, монгол болон англи хэлээр үйлдсэн бөгөөд эх бичвэр тус бүр нь адил хүчинтэй байна. Хэлэлцээрийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД  
УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ  
ОНЦГОЙ БҮС  
МАКАОГ ТӨЛӨӨЛЖ



ЧАНЬ ХОЙ ФАН  
Засаг захиргаа,  
хууль зүйн нарийн бичгийн дарга

МОНГОЛ УЛСЫГ  
ТӨЛӨӨЛЖ



Ц.НЯМДОРЖ  
Хууль зүй, дотоод хэргийн сайд